

---

## ГАРЧИГ

Д.Д	НЭР	ХУУДАСНЫ ДУГААР
1	<b>ГЕОЛОГИЙН СУДАЛГАА</b>	2
2	<b>УУРХАЙН ХИЛ ХЯЗГААР, ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО</b>	7
3	<b>УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА</b>	8
4	<b>УУРХАЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ ДАРААЛАЛ, АШИГЛАЛТЫН СИСТЕМ</b>	9
5	<b>ДЭД БҮТЭЦ БА БУСАД ПРОЦЕССУУД</b>	11
6	<b>ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	12
7	<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	16
8	<b>НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	20
9	<b>УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС</b>	26

## БҮЛЭГ I. ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

### Ордын тухай ерөнхий мэдээлэл


Физик газар зүй: “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урд зүгт 45км, Шувуун фабрик- Туул тосгоноос баруун хойш 4.5км-т (шулуун зайгаар) Туул голын хөндийд оршино.

“Итгэл түшиг”ХХК нь “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” (2014 оны 01-р сарын 09-ний өдөр батлагдсан) хуулийн 14-р зүйлийн дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын ордын 21.27 гектар талбайд ашигт малтмал ашиглах MV-021549 дугаартай тусгай зөвшөөрлийг Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Кадастрын Хэлтсийн даргын шийдвэрээр 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр авсан байна. MV- 021549 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Завсар” нэртэй талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000 масштабтай байрзүйн зургийн L-48- 10-B нэрлэвэртэй хавтгайд оршино.

Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээг хүснэгт №1-1-д үзүүлэв Ордын оршиж буй тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн эргэлтийн цэгүүдийн солбилцол:

Хүснэгт№1

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн булангийн эргэлтийн цэгийн солбилцол (WGS-84 эллипсоидод)		Тэгш өнцгийн солбицол (UTM тусгалд)		Талбайн хэмжээ м2 (га)	Олгосон он
		Уртраг	Өргөрөг	X	Y		
“Завсар” элс-хайрганы хольцын орд	MV-021549	1. 106° 30' 14.61"	47° 45' 31.64"	5290586.5663	612716.7616	21.27	2020 оны 03-р сарын 17
		2. 106° 30' 16.66"	47° 45' 32.30"	5290607.7712	612759.0397		
		3. 106° 30' 18.30"	47° 45' 32.69"	5290620.4751	612792.9447		
		4. 106° 30' 18.30"	47° 46' 21.77"	5292135.6516	612763.4686		
		5. 106° 30' 11.97"	47° 46' 21.77"	5292133.0901	612631.7341		
		6. 106° 30' 11.58"	47° 46' 21.48"	5292123.9796	612623.7917		
		7. 106° 30' 10.52"	47° 46' 20.79"	5292102.2496	612602.1457		
		8. 106° 30' 10.36"	47° 46' 20.70"	5292099.4064	612598.8699		
		9. 106° 30' 13.03"	47° 45' 30.95"	5290564.6257	612684.2852		



Уул зүй: Газарзүйн мужлалаар ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харъяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэлд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Талбайн хойд, баруун хойт хэсгээр жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг. Баруун урд болон баруун хойд талаар орших Бөхөг гол, Туул голын хөндий нь нилээд өргөн бөгөөд томоохон тэвш хэлбэртэй тэгшивтэр гадаргуутай аллювийн хөндийгөөс дээшлэхэд налуувтар гадаргууд шилжиж пролювийн дэнж үүсгэнэ.

Ойролцоох хамгийн өндөр цэг нь талбайн зүүн талд орших 1305.0 м тоот өндөрлөг, хамгийн нам дор цэг нь туул голын хөндийд 1203.0 м байна. Гадаргуугын гарш илэрцийн хувьд дунд зэргийн төлөв байдалтай.

Ус зүй: Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Дүүргийн хэмжээнд Туул, Бөхөг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг бөгөөд эдгээр голуудын гольдролын өргөн нь 30-70 м, гүн нь 0.5-1.5 м, урсгалын хурд дундажаар 1.0-1.6 м/сек гэж өмнөх судлаачид тогтоосон байна.

Дүүргийн талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм.

Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг уруугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бөхөг, Түргэний голд цутгадаг. Судалгааны талбайн ойр орчимд олон тооны булаг шанд, гүний өрөмдмөл худаг байдаг бөгөөд энэ нь унд ахуйн хэрэглээний усны хэрэгцээг хангадаг.

Манай хайгуул хийсэн MV-021098 тооташиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд ямар нэгэн булаг шанд, өрөмдмөл худаг байдаггүй.

---

Уур амьсгал: Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой.

Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Хамгийн хүйтэн үе нь 1-р сард  $-38^{\circ}\text{C}$ , дулаан нь 7-р сард  $+33^{\circ}\text{C}$  хүрнэ. Жилд унах тундасны дундаж хэмжээ 230-350 мм-с хүрдэг, түүний 60-70% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 30-40% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг.

Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 5-9 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан дундажаар 10-30 см орчим байдаг.

Хөрс: Хайгуул хийсэн талбай ландшафт геохимийн мужлалаар ой, хээрийн бүсэд хамаарагдана. Уулархаг хэсгээрээ хар шороон, түүнээс доошлоход уулын нугын хар, хар хүрэн, хүрэн бор, хөндий хотгор газартаа бараан өнгийн хөрс зонхилсон бүслүүрлэг зүй тогтоцтой байна.

Хөрс бий болох үйл явц нь хөрсний өнгөн давхарга дахь биологийн үйл явц зэргээр тодорхойлогдоно.

Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур  $+8.8^{\circ}\text{C}$  байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог байна.

Арваннэгдүгээр сараас хоёрдугаар сар хүртэл хөрсний дундаж температур  $-3.6^{\circ}\text{C}$   $-13.2^{\circ}\text{C}$  хүртэл буурдаг ба гуравдугаар сараас аравдугаар сар хүртэлх хугацаанд  $+0.3^{\circ}\text{C}$   $+29^{\circ}\text{C}$  хүрдэг. Зуны их халуун саруудад хөрсний гадаргуугийн температур  $+35^{\circ}\text{C}$  хүрдэг. Өвлийн цасан бүрхүүлтэй, хүйтэн өдрүүдэд хөрсөн дээр хамгийн бага температур  $-40^{\circ}\text{C}$  хүрдэг.

Хөрсний хөлдөлт ихэвчлэн арваннэгдүгээр сараас гуравдугаар сарын хооронд болдог байна. Хөрсний улирлын хөлдөлтийн дундаж гүн, хугацаа нь хахир хатуу өвлийн улирлуудад янз бүр байдаг.

Улирлын хөлдөлтийн явцын дундаж гүн шаварлаг хөрсөнд 2.0 м, элсэрхэг хөрсөнд 2.5 м, хайргархаг хөрсөнд 3.0 м хүрдэг байна. Хөлдөлтийн гүн нь хөрсний төрөл, найрлага, чийгийн агууламжаас хамааран янз бүр байх боловч ерөнхийдөө 3.0 м-ээс хэтэрдэггүй. Цэвдэгшилийн мужлалаар алаг цоог тархалттай бүс нутагт хамаарах боловч тусгай зөвшөөрөлтэй талбайд цэвдэгшил ажиглагдаагүй.

Амьтан ургамал: Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй юм.

Уулархаг хэсгээрээ шинэс, хуш, нарс зэрэг модод ургахаас гадна ой модтой уулархаг газартаа чоно, бор гөрөөс, талархаг газартаа тарвага, хярс, үнэг, зурам, огтоно, жигүүртнээс шаазгай, шар шувуу, хэрээ, хур, сойр зэрэг ан амьтантай ба олон төрлийн шавьж байна. Туул голдоо зэвэг, хадран, тул зэрэг агнуурын загастай.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Хүн амын суурьшил нь бусад дүүрэг нутагтай харьцуулахад маш их нягтралтай. Нутгийн оршин суугчдын ихэнхийг халх ястан эзлэх ба манай Монгол орны бүх үндэстэн, ястан оршин суудаг.

---

Нутгийн угуул иргэд нь мал аж ахуй, газар тариалан эрхлэхийн зэрэгцээ уул уурхайн олборлох салбар болох элс-хайрга, чулууны карьерын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ажилладаг.

“Завсар” нэртэй элс-хайрганы хольцын орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урд зүгт 45км, Шувуун фабрик-Туул тосгоноос баруун хойш 4.5км-т (шулуун зайгаар) Туул голын хөндийд оршино.

Эдийн засгийн төвийн бүсд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харъяалагдана. Жилийн альч улиралд авто замын тээврээр уг ордын дүүрэгт зорчин очих боломжтой.

Сүүлийн жилүүдийн геологийн судалгаагаар тус дүүрэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн олон ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, карьерийн аж ахуйнууд үйл ажиллагаагаа явуулж байна.

## **1.2. Ордын геологийн тогтоц**

Геологийн тогтоцын хувьд “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын орд (цаашид “Завсарын орд” гэх ) нь Туул голын орчин үеийн аллювийн гаралтай нэг төрлийн хурдаснаас тогтоно.

Завсарын орд дахь элс-хайрганы хурдсууд нь Туул голын хөндийд тогтсон, хайгуулхийсэн талбайн урт нь 1200 м, өргөн нь 120-170 м байна.

Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын хөндийн аллювийн хурдас болох элс- хайрганы хольцоос тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдээ нэг төрлийн жигд найрлагатай, сараал, шаравтар саарал өнгөтэй байна. Энд хийсэн хайгуулын талбай дахь элс-хайрганы хольцын дотор өөр төрлийн болон онцгой ялгарах чулуулгийн үе судлууд байхгүй байна.

Ордын элс-хайрганы хольц дахь 5мм-ээс том хэмжээтэй хэсэг буюу хайрганы агуулга нь 41.9%-56.1%-д хэлбэлзэх ба дунджаар 50.6%, 5 мм-ээс жижиг хэмжээтэй хэсэг буюу элсний агуулга нь 43.9%-58.1% хэлбэлзэх ба дунджаар 49.4% байна.

Завсарын орд дахь элс-хайрга нь ширхэгийн бүрэлдэхүүний хувьд ерөнхийдөө нэг төрлийн тогтвортой бөгөөд элс нь кварц-хээрийн жоншны найрлагатай, хайрга нь зонхилж метаморфжсон элсэн чулуу, боржин, кристалл-витрокластик туф байна.

Хайрган дахь нимгэн үзүүрлэг ширхэгүүд 11.2%, их төлөв бөөрөнхий хэлбэртэй, сайн мөлгөржсөн, гадаргуу нь толигор байх ба мөлгөржилт муутай хэсэг маш бага байна.

Хайгуулын ажлаар элс-хайрганы хольцын судлагдсан зузаан нь 3.2-4.5 м-т хэлбэлзэх ба дунджаар 3.8 м байна. Хайгуул хийсэн талбайд хөрсний ус 1.6-2.2 м-ээс гарсан байна.

## **1.3. Гидрогеологи**

Завсарын орд нь сонгины элс-хайрганы хольцын ордтой нэг хөндийд оршдог тул гидрогеологийн нөхцөлийн хувьд ижил юм.

Сонгины элс-хайрганы хольцын ордод 1978 онд хийсэн судалгаагаар туул голын хөндийд голоос тэжээгдэл авдаг газрын доорхи усны давхарга ихэнхдээ 4м, түүнээс доош гүнээс илэрдэгийг тогтоожээ. Сонгины

амралтаас баруун урагш 1 км-ийн зайд 1977 онд өрөмдсөн гидрогеологийн цооногт газрын доорхи ус 16.6 м-т илэрсэн бөгөөд уст давхаргын зузаан 45.0-50.0 м орчим байжээ.

## БҮЛЭГ II . УУРХАЙН ХИЛ ХЯЗГААР, ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО

### 2.1. Ил уурхайн ашиглах талбайн сонголт ба хил хязгаар

Завсарын элс-хайрганы хольцын ордын MV-021549 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 212781.4м<sup>2</sup> буюу 21.28 га газрын 173068м<sup>2</sup> буюу 17.3 га-д хийгдсэн хайгуулын ажлаар 4 блокод бодит, 1 блокод боломжтой нөөцийг тооцжээ.

ЭБМЗ-ийн 2011 оны 07-р сарын 08-ны өдрийн хуралдааны ХХ-13-09 дугаартай дүгнэлт, АМГТГ-ын даргын 2011 оны 08-р сарын 24-ний 339 дугаартай тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн бодитой (В) 609668.8м<sup>3</sup> нөөцийн хүрээнд хамрагдах усны түвшнээс дээш орших бодитой (В) 351660.80 м<sup>3</sup> нөөцийн хэмжээнд техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулав.

Нөөцийн хил хязгаар тусгай зөвшөөрлийн хилтэй давхацсан болон гадагш бага зэрэг гарч байгааг тооцон хана (борт)-ын тогтворжилтын налуугийн өнцөг 45° байх нөхцөлөөр тооцож, уурхайн хүрээг тооцоолов

### 2.2. Үйлдвэрлэлийн нөөц

Үйлдвэрлэлийн нөөцийг олборлолтын үед гарах технологийн хаягдлыг тооцсоны үндсэн дээр тодорхойлов.

Завсарын ордын үйлдвэрийн магадласан нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Хүснэгт №2

Геологийн нөөц					Ашиглалтын хаягдал		Бохирдолт		Үйлдвэрийн магадласан нөөц				
Блокгийн дугаар	Ордын нөөцийн блокгийн хилээр хөрс хуулах талбай, м	Хөрсний зузаан, м	Хөрсний эзлэхүүн, м <sup>3</sup>	Геологийн нөөц, м <sup>3</sup>	%	Элс-хайрга м <sup>3</sup>	%	Элс-хайрга м <sup>3</sup>	Уурхайн хүрээний хилээр нөөцийн блокгийн хөрс хуулах талбай, м <sup>2</sup>	Хөрсний зузаан, м	Хөрсний эзлэхүүн, м <sup>3</sup>	Магадлагдсан үйлдвэрлэлийн нөөц	
												зэрэг	Элс-хайрга м <sup>3</sup>
В-I	38593.0	0.45	17366.85	81045.30	8	6483.62	1.53	1239.99	40870.46	0.55	22478.75	В <sup>1</sup> -I	75801.67
В-II	38970.0	0.45	17536.50	79888.50	8	6391.08	1.53	1222.29	39701.0	0.55	21835.55	В <sup>1</sup> -II	74719.71
В-III	50928.0	0.35	17824.80	102874.56	8	8229.96	1.53	1573.98	51608.53	0.45	23223.84	В <sup>1</sup> -III	96218.58
В-IV	44302.0	0.25	11075.50	87274.94	8	6982.00	1.53	1335.31	45587.76	0.35	15955.72	В <sup>1</sup> -IV	81628.25
Нөөц	172793.0	0.37	63803.65	351083.3	8	28086.66	1.53	5371.57	177767.75	0.475	83493.86	В <sup>1</sup>	328368.21

### БҮЛЭГ III. УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА

#### 3.1. Уурхайн жилийн хүчин чадал

2024 онд 47,0 мян.м<sup>3</sup> элс хайрга олборлохоор төлөвлөгөөнд тусгалаа.

#### 3.2. Уурхайн ажиллах горим

Уурхай нь 4-р сарын 1- нээс 11-р сарын 1 хүртэл 7 сар ажиллана.

Тус уурхай нь жилийн баяр ёслолын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо:

- Жилийн нийт ажиллах хоног - 214
- Баяр ёслолын хоног - 4
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулах хоног - 20
- Цаг уур, нүүдэл, сэлбэгийн хангамжийн саатлаас сул зогсох хоног - 10

Уурхайн цэвэр ажиллах хоног: 214 – 4 – 20 – 10 = 180 хоног

- Хоногт ажиллах ээлж – 1
- Ээлжийн үргэлжлэх хугацаа- 8 цаг

#### 3.3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

“Завсар” элс-хайрганы холимогийн ордын хөрс хуулалт 8.6мян.<sup>3</sup>, элс хайрга олборлолт 47,0 мян.м<sup>3</sup> бүтээгдэхүүн гаргалт 43.9 мян.м<sup>3</sup> ил аргаар ашиглахаар 2024 оны төлөвлөгөөнд тусгаж байна.

#### 2024 оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт №3

	4	5	6	Эхний хагас жил	7	8	9	10	11	Сүүлийн хагас жил	Нийт
Хөрс хуулалт мян.м <sup>3</sup>	2.0	3.0	1.0	6.0	2.0	0.66				2.66	8.66
Элс хайрга олборлолт мян.м <sup>3</sup>	2	5	5	12	10	10	10	4.7		34.7	56.04

## **БҮЛЭГ IV. УУРХАЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ ДАРААЛАЛ, АШИГЛАЛТЫН СИСТЕМ**

### **4.1. Уурхайн талбайг ашиглах дараалал**

Уурхайн талбайн ашиглах дараалалыг элс-хайрганы холимогийн давхаргын тогтоц, уурхайн хил хязгаар дахь хөрс хуулалтын дундаж коэффициентийг баримталж, уулын ажлыг аль болох жигд барьж явуулах, сонгож авсан тоног төхөөрөмжийн жигд ажиллагааг хангах зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн тогтоов

### **4.2. Ашиглалтын систем**

#### **4.2.1. Ашиглалтын системийн сонголт**

Элс-хайрганы холимогийн ордын давхаргын тогтоцоос хамааруулан авто тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар сонгов.

#### **4.2.2. Уулын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжийн сонголт**

Уулын ажлыг “Итгэлтүшиг” ХХК өөрийн хөрөнгө болох тоног төхөөрөмжүүдийг түшиглэн явуулахаар төлөвлөгөөнд тусгаж байна.

Утгуурт ачигчаар элс-хайрганы хольцыг, анхдагч түүхий эд хүлээн бункерт хийх ангилагдсан элс, хайргыг тус бүрд нь овоолго үүсгэх, бүтээгдэхүүний борлуулалт хийхэд ачилт хийх, хөрс ачих, нөхөн сэргээлт хийх ажлыг гүйцэтгэхэд ашиглана. Энд БНХАУ-д үйлдвэрлэсэн ZL-50E маркийн 3.0 м<sup>3</sup> шанаганы багтаамж бүхий утгуурт ачигчийг ашиглана.

Утгуурт ачигч нь хоногт 1 ээлжээр ажиллах бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг.

### **4.3. Уурхайн тээвэр**

“Завсар” элс-хайрганы холимогийн ордын уурхайн жилийн хүчин чадал, уулын ажлыг явуулах технологиос хамааран автотээврээр тээвэрлэнэ.

#### **4.3.1. Тээврийн тоног төхөөрөмжийн сонголт**

“Итгэлтүшиг” ХХК-ийн төслийн даалгаварт тусгасан БНХАУ-д үйлдвэрлэсэн 25тн-ын даацтай SHAANXI STR маркийн автосамосвалыг сонгон авч төлөвлөв.

#### **4.4. Хөрсний овоолго**

**Шимт хөрсний овоолго.**



Шимт хөрсийг экскаватороор хуулж түр болон удаан хадгалах зориулалтаар ерөнхий тооцоогоор жилд 0.72 га талбайд 2м дундаж өндөртэй овоолгод байршуулна.

Хөрсний гадаад, дотоод овоолгыг түр хадгалахдаа ZL-50 шууд утгуурт ачигчийн тусламжтай хэлбэршүүлж, хөрс бохирдох, салхинд хийсэхээс хамгаалж нягтаршуулсан байна.

#### **4.5. Элс-хайрганы холимогийг шигшин ангилах**

##### **4.5.1. Элс-хайрганы холимогийг шигшин ангилах цехийн хүчин чадал**


Элс-хайрганы холимогийг ангилах цех нь зөвхөн улирлын байдлаар ажиллах ба жилд цэвэр 180 хоног, 8 цагийн 1 ээлжээр, шигшин ангилах төхөөрөмж нь 20 м<sup>3</sup>/цагийн хүчин чадалтайгаар ажиллана.

##### **4.5.2. Элс-хайрганы холимогийг шигшин ангилах цехийн тоног төхөөрөмж**

Жилд боловсруулах элс-хайрга 47000 м<sup>3</sup>/жил\*1.2 = 56400 м<sup>3</sup>/жил (сийрэгжсэн байдлаар) Цехийн ажиллах горим нь уурхайн ажиллах горимтой нэг адил ажиллана.

Жилд ажиллах хуанлийн хоног –	183
Засварт зогсох хоног –	6
Амралт, баяр ёслолын хоног –	31
Цаг агаарын болон болзошгүй саатлын хоног –	5
Жинхэнэ ажиллах хоног –	141
Хоногт ажиллах ээлж –	1
Ээлжийн үргэлжлэх хугацаа цаг –	8
Ээлжийн тооцооны бүтээл –	400 м <sup>3</sup> /ээлж
Цагийн бүтээл-	50м <sup>3</sup> /цаг ба 78.5 тн/цаг байна.

Элс-хайрганы хольцыг боловсруулах үйлдвэрийн технологийн холболтын бүдүүвч



## БҮЛЭГ V. ДЭД БҮТЭЦ БА БУСАД ПРОЦЕССУУД

### 5.1. Уурхайн ундны усны хэрэгцээ

Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг уурхайн ойр байдаг булагийн уснаас зөөвөрлөн хангана.

### 5.2. Уурхайн засвар, техникийн үйлчилгээ

Уурхайн засвар техникийн үйлчилгээний дэд бүтэц нь ухааж ачих, зөөж тээвэрлэх, элс, хайргыг бутлах, шигших, угаах тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалт бүхий засварын жижиг газар байна.

Уурхайн техник тоног төхөөрөмжийн үзлэг засвар үйлчилгээг сард нэг удаа хуваарийн дагуу хийнэ. Уурхай дээр гүйцэтгэж чадахгүй ажлыг хийж чадахуйц газар, компаниудад захиалга, гэрээ хэлцлээр зохицуулан гүйцэтгэнэ.

### 5.3. Уурхайн барилга байгууламж

Уурхайд нийт 20 хүн ажиллана. Нийт ажиллах хүчний ихэнх хэсгийг Улаанбаатар хотын дүүргүүдээс бүрдүүлэх чиглэлийг барина. Уурхай ба боловсруулах цех нь нүсэр бүтэцгүй улирлын чанартай 1 ээлжээр ажиллах учир уурхай дээр ажиллагсдыг хооллох, түр амрах зориулалттай овор бага вагончик юмуу энэ хэлбэрийн авсаархан байраар төлөвлөж байна

#### 5.4. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь бутлуурууд, шигшигч, конвейер, угаах төхөөрөмж болон усны насос, засварын цех бусад жижиг хэрэглэгчид байна. Элс-хайрганы бутлуур, шигшүүр, угаах тоног төхөөрөмж, засварын талбай, автомашины зогсоол, орон сууц болон бусад барилга, явган зорчигчдын талбай зэргийг харанхуй үед гэрэлтүүлэх шаардлагатай.

#### **ЗУРГАА. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, газрын гүний усан орчин зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдлоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгч байна.

#### **6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

**Тоосжилтыг бууруулах:** Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд болон овоолго, уурхайн догол, мөргөцгүүдээс тос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг, элс хайргыг ачих, тээвэрлэх, буулгах үед үүсэх тоос агаар орчныг бохирдуулахаас гадна ажилчдын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй байдал судалгаанаас харагдаж байна. Иймд эх үүсвэр тус бүр дээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

##### ***Экскаваторын ажлын үед:***

- ~ Ажлын талбай болон мөргөцгийг услах
- ~ Экскаваторын кабиныг битүүмжилж, тоос шүүж агааржуулагч төхөөрөмжөөр тоноглох
- ~ Ээлж тутамд экскаваторын кабиныг чийгтэй алчуураар цэвэрлэж байх

##### ***Авто зам***

- ~ Бульдозер болон автогрейдерээр уурхайн замыг байнга хусч тоос үүсгэж буй хөрс, чулууг цэвэрлэж байх
- ~ Дулааны улиралд хуурайшилтай үед замыг услах зэргээр тоосжилтыг багасгах
- ~ Олон салаа зам гаргахгүй байх

##### ***Уурхайн ажлын бус хажуу болон дотоод овоолгод***

- ~ Талбайг услах
- ~ Нөхөн сэргээлт хийх
- ~ Элс хайргыг ачих, тээвэрлэх үед ажиллагсдыг тоосжилтоос хамгаалах хэрэгслээр (амны хаалт) байнга хангах
- ~ Технологийн шаардлага хангахгүй элс хайрга болон бусад төрлийн чулуулаг, бусад хог хаягдлыг уурхайн ашиглагдсан орон зайд буюу овоолгод булж дарах

**Хорт хий бууруулах:** Өмнөх судалгаанаас үзэхэд уурхайн машин, механизмуудын дотоод шаталтатхөдөлгүүрийн яндангаас гарах утаа, хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болж байна.

Хүнд даацын машин, механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж ижил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулах

## **6.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

Нэгэнт холбогдох газруудаас зохих зөвшөөрлийг нь аваад үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа учир ТЭЗҮ-д тусгасан ордыг ашиглах дарааллыг нарийн чанд мөрдөж ажиллана. Хөрс хуулалтын ажлыг эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.5 м орчим зузаантай хөрсийг бульдозероор 2 тийш түрж овоолгыг ачиж, тээвэрлэн уурхайн зүүн талд 3 метрийн өндөртэй овоолго үүсгэж байршуулах хэрэгтэй. Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцөлийг хангаж өгдөг.

### ***Элс хайрганы хольцын ордын ашиглалтын үндсэн процессууд:***

- ~ Үржил шимт, өнгөн хөрс хуулалтын ажил
- ~ Элс хайрга олборлолтын ажил
- ~ Бутлан ангилах, эцсийн бүтээгдэхүүн гаргах
- ~ Овоолгын тэгшлэлтийн ажил
- ~ Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил зэрэг болно.

Газрын гадарга хөрсийг элэгдлээс хамгаалахын тулд орчиндоо мод, сөөг тарих, олон наст тарих, уурхайн эргэн тойронд хөрсний элэгдлээс хамгаалах өдөр тутмын анхаарал тавих нь зүйтэй.

Эдгээр талбайн хөрс тэнд явуулж буй ажил, үйлчилгээнээс хамааран шингэн, хатуу хог хаягдлаар бохирдох үндэстэй. Зөвхөн уурхайн орчинд буй болох ахуйн хог хаягдлыг тооцож үзэхэд тэнд жорлон, хогийн болон хаягдал тосны сав байх шаардлагатай..

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа (тосгон, уурхай, шахахуун хадгалах-түгээх цэг, ус татамжийн байгууламж) объектуудад Монгол улсын ариун цэврийн хуулийг мөрдөж ажиллана.

## **6.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- ~ Нөхөн сэргээлтэнд зориулж үржил шимт өнгөн хөрсийг үйлдвэрийн талбайн гадна тусгайлан овоолж бэлтгэх;
- ~ Хөрсний овоолгыг 1 жилээс хэтрүүлэхгүйгээр нөхөн сэргээх ажилд ашиглаж байхаар зохион байгуулах;
- ~ Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалтын MNS 5916 : 2008 стандартыг хэрэгжүүлэх;
- ~ Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн MNS 5917:2008 стандартыг хэрэгжүүлэх;
- ~ Газрын гадаргуугийн хэлбэр дүрсийг анхны төрх байдалд нь ойртуулан засах;
- ~ Хуулан авсан үржил шимт хөрсийг уурхайн талбайн гадна түүний эрэг ирмэгээс доод тал нь 10 м-ээс гадагш зайд 20-иод м-ийн өргөн, 2 м-ээс илүүгүй өндөртэйгээр ордын уртын дагуу чиглэлтэйгээр овоолго хийж хадгалах.
- ~ Мөн ашиглалт хийсэн орон зайд ч хучдас чулуулгийн овоолгыг хийх нь өнгөн хөрсийг эвдэхгүй байх ач холбогдолтой бөгөөд олборлолтын ажлыг явуулах явцад аль болохоор энэ зарчмыг баримтална.

- ~ Хучдас чулуулгийг ихэвчлэн уурхай ирмэгт зайчилсан газарт байрлуулна. Үржил шимт өнгөн хөрсний овоолгыг дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах.
- ~ Үржил шимт өнгөн хөрсийг бульдозероор хуулах ба доод тал нь 20 м, дээд тал нь нэг талдаа 20-40 м зайд түрж тусгай овоолго хийх.
- ~ Энэ ордын өнгөн хөрсийг хуулах ажлыг жил бүрийн оны 5 дугаар сараас эхлэх ба 10 дугаар сар гэхэд олборлох ажлыг зогсоох. Үржил шимт өнгөн хөрсийг хучаас хурдас чулуулгийн овоолготой хольж овоолго хийхийг хориглоно.

#### **6.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- ~ Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад дүүргийн болон гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.
- ~ Төсөл хэрэгжүүлэх талбайд гадаргын болон гүний ус байхгүй боловч хур тунадас ба үерийн усаар элс хайрга болон бусад дисперслэг, нарийн ширхэгтэй материал зөөгдөж тархан газрын гадаргыг бохирдуулахаас хамгаалж далан байгуулах, суваг, шуудуу татах.

#### **6.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- ~ Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад орчны төлөв байдалд хяналтын шинжилгээ үе үе хийж байх шаардлагатай.
- ~ Ургамал хөрсний бохирдлоор дамжиж гадаргын болон хөрсөн доорхи ус, улмаар хүн, малын ундны ус бохирдох талтайг анхаарах хэрэгтэй.
- ~ Мөн үйлдвэрээс гарах хуурай хог хаягдлыг тогтоосон журмын дагуу зайлуулж бохирдуулж болох бүх эх үүсвэрийг байнгын хяналтанд байлгавал зохино.
- ~ Үйлдвэрийн орчим сонгож авсан тодорхой цэгдүүдээс хөрсний дээж авч хүнд металлын агууламжийг тодорхой цаг хугацааны зайтай шинжилж дээр тогтоосон хөрсний химийн найрлагыг үндэслэн анхны суурь хэмжээнээс хэр нэмэгдэж буй эсэхийг хянаж байх явдал зайлшгүй чухал.

#### **6.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах**

Төслийн явцад технологийн дагуу, зүй зохистойгоор ашиглаж, олон салаа зам гаргахгүй, тогтсон нэг чиглэл, замаар техникийг зорчуулах, хуурай болон шингэн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, шатах тослох материал, барилгын материал түүхий эдийг эмх цэгцтэй хадгалж ашиглах, мөн тайлангаар өгөгдсөн зөвлөмж, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгож ажиллах, нөхөн сэргээлтийг олборлолттой зэрэгцүүлж явах нь алдагдсан буюу алдагдаж болзошгүй экосистем хуучин төрхдөө ойртох нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **6.7 Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

*Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:*

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих

- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

**Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ**

**Ажиллах хүчний тоо, эх үүсвэр**

Уурхайн үйл ажиллагаанд нийт 16 хүн ажиллана. Тус компани ажиллагсдын хөдөлмөр хамгааллын асуудалд анхаарал тавьж зааварчилгаа өгөх, ажлын хувцас, ажлын хамгаалах хэрэгсэл (бээлий, маск, гар багаж г.м)-ээр хангах ариун цэвэр, эрүүл ахуйн зардал зэргийг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

**Нөлөөлөлд өртөгчийн асуудал**

Элс хайрганы холимгийн ордын ойролцоо байгаа гэр хорооллын айлууд нь нөлөөлөлд өртөгч болох ба элс хайрга олборлох явцад дэгдэх тоос шороо, дуу чимээ зэрэг нь уурхайн нөлөөллийн бүсэд байрлах иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.

Элс хайрганы хольцын ордыг ашиглах явцад бэлчээрийн ашигтай талбай устгах, тэр орчмын шимт хөрс, ургамлын нөмрөг салхины чиглэлийн дагуу тоос, шороогоор дарагдах, машины олон салаа зам гаргасан тохиолдолд хөрсний эвдрэл, элэгдэл үүсэх зэрэг сөрөг нөлөө ажиглагдах болно.

Иймд бидний дараагийн бүлгүүдэд өгөх зөвлөмжийг хатуу баримтлан ажиллахыг зөвлөж байна.

- Ажил эхлэхийн өмнө ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол гамшгаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны самбар ажиллуулах, ажлын хувцсаар хангаж, галын хортой ажиллах заавар өгч, эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх буланг байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байх ёстой.
- Уурхайн ажиллагсад тусгай зориулалт бүхий амны хаалт, хувцас хэрэгсэл олгох.
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргах
- Орон сууц, хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэж байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд сургалтанд хамруулах
- Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс бохирын худагтсар бүр хуваарийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.
- Уурхайн тоног төхөөрөмж, ахуйн хаягдал цэг, сав агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцлийг хангах зорилгоор зөв байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

**Үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх гол нөлөөллийн талаар**

**Хүснэгт 2.2**

**Гол сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, үргэлжлэх хугацаа**

№	Гөслийн нөлөөлөл	гол	Нөлөөлөлд өртөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
---	------------------	-----	------------------	------------------	-------------------

1	Шимт хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
2	Элс, хайрга олборлолт	Геологийн тогтоц, агаар	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
3	Гээвэр	Хөрс, агаар	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
5	Сийрэгжүүлэлт	Агаар, хөрс	Дунд зэрэг	Сийрэгжүүлэлт хийсэн үед

Элс хайрганы ордын олборлолт тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсэний дараа ч сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Сөрөг нөлөөллийн эрчим нь олборлолт эхэлсэнээс хойш ихсэнэ. Элс-хайрга олборлох үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, гадаргын усны горим, агаарын чанар, гадаргын болон гүний усны хэмжээ, чанар өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

## **ДОЛОО . БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **7.1 СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Итгэл түшиг” ХХК нь холбогдох байгууллагатай харилцан уялдаатай ажилладаг ба тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар болон зөрчлүүдээ цаг тухайд нь арилган ажилладаг болно. Манай компани нь Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2024 онд нийт 5436.0 мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь уулын ажлын болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

**СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗАРДАЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>АГААР ОРЧИН</b>						
